



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: statgreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.09.09 № 55

Монгол Улсын хүн амын нутагшилт,
суурьшлын талаар

Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын талаарх асуудлаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

1.2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын нийт хүн амын хэдэн хувь нь Улаанбаатар хот, аймгийн төвийн 21 сум болон бусад 309 суманд оршин сууж байгаа талаарх тоон мэдээлэл;

2.Статистик мэдээллээр нийт 330 сумаас 1500-аас цөөн хүн амтай 14 сум, 1501–3000 хүн амтай 148 сум, түүнчлэн газар нутаг нь 1000 км.кв-аас бага аймгийн төвийн бус 13 сум байна. Эдгээр сумын оршин суугч иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний хүртээмж, чанарын талаарх судалгаа, тэр дундаа эрүүл мэнд, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын хүртээмж, түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хэмжээ, тухайн сумын эдийн засгийн бүтэц, бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо, хэлбэр, ангилал, тухайн сумын хөдөлмөр эрхлэлтийн байдлын /төрийн албан хаагчдын тоо/ талаарх мэдээлэл;

3.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх хууль 21 аймгийн төвд хэрхэн хэрэгжиж байгаа талаарх мэдээлэл;

4.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн дунд шат болох сумдыг нэгтгэн томсгож, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарьт өөрчлөлт оруулах эсэх талаар баримталж буй Засгийн газрын бодлого, төлөвлөлт, судалгааны талаарх мэдээлэл.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

П.САЙНЗОРИГ

2026000161